



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Хяналтын тоо батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам" -ын 1.9 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам" -ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын зээлийн сангаас олгох дотоодын тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид 2024-2025 оны хичээлийн жилд хамрагдах суралцагчдын хяналтын тоо, зарцуулах төсвийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан хяналтын тоо, зарцуулах төсвийн хэмжээг баримтлан хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад зохих тэтгэлгийг олгох, жил бүрийн улсын төсвөөс шаардагдах төсвийн болон холбогдох судалгаа, мэдээллийг гаргаж, тухай бүрд тайлагнаж ажиллахыг Боловсролын зээлийн сан /О.Сийлэгмаа/-д даалгасугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Дээд боловсролын газар (Ж.Ариунболд), Гадаад хамтын ажиллагааны газар (Б.Энхбаяр), Санхүү хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-т тус тус даалгасугай.

САЙД  П.НАРАНБАЯР



14251 0459

Боловсролын сайдын 2025 оны
... дүгээр сарын ... өдрийн
... дугаар тушаалын хавсралт

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД ОЛГОХ
ХЯНАЛТЫН ТОО, ТӨСВИЙН ХЭМЖЭЭ

Хяналтын тоо, төсөв

Д/д	Хөтөлбөр	Хамрах хүрээ	Суралцагчийн тоо	Санхүүжилт (тэрбум.төг)
1	Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг дотоод	Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч	1,334	4.80
		Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгайлан заасан ахисан түвшний сургалтад дагалдан ажиллах тэтгэлгээр суралцагч	70	0.91
2	Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагч	Засгийн газар хоорондын гэрээний дагуу гадаад улсаас Монгол Улсад суралцах суралцагч	298	2.10
3	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	580	1.90
4	Зарим эрэлттэй мэргэжлээр суралцагч	Сувилагч	3,300	6.40
5		Хөдөлгөөн засалч	110	0.28
6		Хөдөлмөр засалч	40	0.12
7		Нийгмийн ажил	65	0.20
8		Номын сан судлал	20	0.06
9		Сэтгэл судлал	18	0.05
10		Хоол зүйч	55	0.17
11		Арга зүйч	5	0.02
12		Хэл засал	5	0.02
13	Зорилтот бүлгийн суралцагч	Бүтэн өнчин суралцагч	890	4.20
14		Эцэг, эх нь хоёулаа, эсхүл хагас өнчин бол эцэг/эх нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн суралцагч	400	1.00
15		Хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрх	1,600	4.00
16		Цаатан, урианхай, тува өрхийн нэг иргэн	50	0.16
17		"Монголын сайхан бичигтэн" уралдааны эхний гурван байрт шалгарсан суралцагч	25	0.08
18		Нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа тохиолдолд нэг суралцагч	110	0.28
19	Сургалтын төлбөрийн	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын	2,430	3.90

	хөнгөлөлтөөр суралцагч	байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагч (50%)		
20	Сургалтын зээлээр суралцагч	Тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч	1,695	6.10
21		Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч (50%)	341	1.20
22		Цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан суралцагч	22	0.07
		ДҮН	13,463	38.02
23	Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс үзүүлэх дэмжлэг	Боловсролын ерөнхий хуулийн 12.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч;	-	-
24		Багш өндөр оноо(ЗГ-ын 346-р тогтоол)	480	1.20
25		Багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч	3,000	7.70
26		Боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч	500	1.40
27		Боловсролын ерөнхий хуулийн 12.10-д заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш (хөрвөх)	250	0.70
28		Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-т заасан хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч	430	1.00
29		Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан багш, ажилтны нэг хүүхэд (15 жил тасралтгүй ажилласан тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагч)	560	2.30
		ДҮН	5,220	14.30
30	Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг гадаад	Магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах төрийн албан хаагч	26	12.8
		Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч	26	
		Техникийн боловсролын сургалтын байгууллагын олон улсын хөтөлбөрийг дотоодын сургуульд төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээрээ гадаадын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр дэвшин суралцагч	25	

31	Дэлхийн шилдэг их сургуульд сургалтын зээл	Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Times Higher Education World University Rankings", эсхүл "Academic Ranking of World Universities" байгууллагын сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-50-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагч	74	15.3
32	Монгол Улсын ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт суралцагчид	Бэлтгэл хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох бөгөөд орон нутгийн суралцагчид дотуур байрны зардал олгоно.	330	1.2
33	Монгол Улсын ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн тэтгэлэгт хөтөлбөрт суралцагчид	Тэтгэлэгт хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардал (дотуур байрны болон хүнсний зардал)-ын тэтгэлэг олгоно.	315	52.0
34	Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцагчид	Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцах суралцагчдад олгох сургалтын төлбөр болон амьжиргааны зардал (дотуур байрны болон хүнсний зардал)	46	5.6
		ДҮН	842	86.9
			19,525	139.22